

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/023/НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Факс: 70272582, Эхний туслах: tuv@audit.gov.mn
Хаяг: www.audit.mn

2025.03.24 № 01/2025
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР
СУМЫН ЗАСАГ ДАРГА
В.БАТБОЛД ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Борнуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэж, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чангатган, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллажээ.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Борнуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 4 дүгээр тогтоолд Борнуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд нийт 1,065,240.7 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталснаас гүйцэтгэлээр 1,249,068.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 117,3 хувиар биелүүлж, аймагт төвлөрүүлэх 1 нэр төрлийн орлогыг 2,842.7 мянган төгрөг, орон нутагт төвлөрүүлэх 6 нэр төрлийн орлогыг 173,227.6 мянган төгрөгөөр нийт 176,070.3 мянган төгрөгөөр тасалсан байна.

• 4126020602

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Борнуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 18-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 8 зорилт 85 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 77,7%-тай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛӨХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,511,421.91	1,596,170.08
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	922,353.07	924,332.8
3	1.1.3 АВЛАГА	338,737.64	337,368.01
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	250,331.2	334,469.27
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,032,358.86	11,478,081.64
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,032,358.86	11,478,081.64
7	1.2.2.02 Биет хөрөнгө	5,600,208.19	10,037,962.97
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	1,432,150.67	1,440,118.67
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	8,543,780.76	13,074,251.72
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	41,963.42	43,710.9
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	41,963.42	43,710.9
12	2.1.1.03 Өглөг	41,963.42	43,710.9
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,501,817.35	13,030,540.82
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	8,501,817.35	13,030,540.82
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	1,462,061.88	1,462,061.88
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	6,864,866.74	11,393,626.71
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	174,888.73	174,852.23
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	8,543,780.76	13,074,251.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,567,307.71	7,944,631.92
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,144,247.91	1,050,362.36
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	741,164.97	812,550.06
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	741,164.97	812,550.06
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	105,989.67	109,823.11
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	297,093.27	127,989.19
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,700,486.39	6,894,269.56
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого	7,071.59	863,829.91
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,722,573.4	-
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,877,085.11	3,410,038.66
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,877,085.11	3,360,646.66
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,838,671.5	3,240,498
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	805,645.46	917,383.63
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,146.27	111,420.17
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,482.13	593,931.53
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	64,721.53	35,338.04
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал	123,952.03	750.00
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	4,200	28,746
19	1.1.2.01.1.07 Томлолт, зочны зардал	7,952.6	5,725
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,307.24	13,523.99
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	1,276,264.23	1,533,679.65
22	1.1.2.01.3 ТАТААС	-	41,543.6
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,413.61	78,605.06
24	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	49,392
25	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,690,222.6	4,534,593.25
26	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	35,414.67	5,869.78
27	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-35,414.67	-5,869.78
28	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,654,807.93	4,528,723.47

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,311,049.68	2,648,829.77
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,279,821.05	1,050,362.36
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	876,738.11	812,550.06
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	105,989.67	109,823.11
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	297,093.27	127,989.19
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	37,711.84	19,771.47
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	87,648.75	84,987.58
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	171,732.68	23,230.13
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	308,655.22	1,598,467.41
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	307,255.22	394,794.31
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	1,400	863,329.91
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	340,343.2
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,722,573.4	0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,952,764.22	2,097,593.75
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,952,764.22	2,097,593.75
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,914,350.61	1,977,445.09
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	805,140.49	917,383.63
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,651.24	111,420.17
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	596,951.23	592,830.48
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	169,964.39	185,384.49
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,000	3,130
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	19,508.45	37,657
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	7,706.6	5,465
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,401.54	13,346.9
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	129,026.67	110,827.41
26	1.1.1.2.01.3 ТАТААС	0	41,543.6
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,413.61	78,605.06
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,358,285.45	551,236.02
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	849,379.11	505,704.37
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	849,379.11	505,704.37
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	849,379.11	505,704.37
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-849,379.11	-505,704.37
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	73,752	35,843.5
34	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0	7,708.43
35	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-73,752	-43,551.93
36	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	435,154.35	1,979.73
37	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	487,198.73	922,353.07
38	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	922,353.07	924,332.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,742,174	5,742,174
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	105,509.45	105,509.45
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,847,683.46	5,847,683.46
4	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	-674.04	-674.04
5	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	2,654,807.93	2,654,807.93
6	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,501,817.35	8,501,817.35
7	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,501,817.35	8,501,817.35
8	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	36.5	36.5
9	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,501,853.85	8,501,853.85
10	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-36.5	-36.5
11	1.7 Тайлант үеийн үр дүн	4,528,723.47	4,528,723.47
12	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	13,030,540.82	13,030,540.82

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,043,682.50	4,251,583.20	(207,900.70)	105.14
11	Татварын орлого	962,240.70	1,050,362.36	(88,121.66)	109.16
110	Орлогын албан татвар	673,880.70	812,550.06	(138,669.36)	120.58
1100	Хувь хүний орлогын албан татвар	673,880.70	812,550.06	(138,669.36)	120.58
113	Хөрөнгийн албан татвар	95,860.00	109,823.11	(13,963.11)	114.57
118	Бусад татвар, төлбөр, хураамж	192,500.00	127,989.19	64,510.81	66.49
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	16,500.00	19,771.47	(3,271.47)	119.83
1181	Газрын төлбөр	129,000.00	84,987.58	44,012.42	65.88
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	47,000.00	23,230.13	23,769.87	49.43
12	Татварын бус орлого	3,081,441.80	3,201,220.84	(119,779.04)	103.89
120	Нийтлэг татварын бус орлого	256,150.00	241,694.79	14,455.21	94.36
122	Тусламжийн орлого	2,482,451.30	2,619,182.85	(136,731.55)	105.51
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	342,840.50	340,343.20	2,497.30	99.27
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,906,848.40	2,329,119.42	577,728.98	80.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,049,161.60	1,821,571.55	227,590.05	88.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,882,983.60	1,701,422.89	181,560.71	90.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	835,997.00	818,710.57	17,286.43	97.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,171.20	100,394.96	4,776.24	95.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	594,044.10	592,830.48	1,213.62	99.80
2104	Хангамж, бараа материалын зардал	39,584.40	29,280.59	10,303.81	73.97
2105	Нормативт зардал	3,380.00	3,130.00	250.00	92.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,800.00	37,657.00	15,143.00	71.32
2107	Томилголт, зочны зардал	8,904.00	5,465.00	3,439.00	61.38
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,583.90	12,579.87	75,004.03	14.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,519.00	101,374.41	54,144.59	65.18
212	ТАТААС	82,000.00	41,543.60	40,456.40	50.66
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	82,000.00	41,543.60	40,456.40	50.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,178.00	78,605.06	5,572.94	93.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,178.00	78,605.06	5,572.94	93.38
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	704,536.80	471,704.37	232,832.43	66.95
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	153,150.00	35,843.50	117,306.50	23.40
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	874,304.27		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	878,828.68		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	64	25	39	39.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	0	2	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	25	6	80.6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31	0	31	-

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	513,061.3	154,378.0
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	513,061.3	154,378.0
3	122	Тусламжийн орлого	513,061.3	154,378.0
4	1221	Хандив тусламж /дотоод/	513,061.3	154,378.0
5	12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	513,061.3	154,378.0
9	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	513,061.3	154,378.0
10	21	УРСГАЛ ЗАРДАЛ	167,193.6	120,378.0
11	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,089.0	120,378.0
12	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,221.4	95,923.5
15	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,880.1	11,025.2
21	2104	Хангамж, бараа материалын зардал	5,134.6	4,449.3
25	2107	дотоод албан томилголт	850.0	-
27	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,649.3	-
29	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,353.5	8,980.0
31	22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	345,867.7	34,000.0
32	2200	Дотоод эх үүсвэрээр	345,867.7	34,000.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аудитын явцад залруулгын алдаа гараагүй байна.

Нийт алдаа, зөрчлөөс 176,070.3 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус, урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 41,305.5 мянган төгрөгөөс бага буюу материаллаг алдаа илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 176,070.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 176,070.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлжээ.

5.2 Зөвлөмж

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд аймагт төвлөрүүлэх 1 нэр төрлийн орлогыг 2,842.7 мянган төгрөг, орон нутагт төвлөрүүлэх 6 нэр төрлийн орлогыг 173,227.6 мянган төгрөгөөр нийт 176,070.3 мянган төгрөгөөр орлого тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын тасалдлыг бууруулахын тулд төлөвлөлтийг бодитой болгох, биелэлтийг улирал тутам дүгнэж орлогын төлөвлөгөө жигд ханган биелүүлэх.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд тус Засаг дарга шилэн дансны 159 мэдээлэл байршуулахаас 125 мэдээлэл хугацаанд нь, хугацаа хоцроосон 34 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1				1		
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	5	1	4			1		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn